

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2020 оны 05 сарын 15.-ны
САЙД А-79/99 дугаарт бүртгэв.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2020 оны 04 дугаар
сарын 28.-ны өдөр

A/301/1/265
Дугаар ... /.../...

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Усны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Рашааныг зохистой ашиглах, хамгаалах журам”-ыг нэгдүгээр, “Рашааны ордын паспорт”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Энэхүү журмын хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт, аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, Сав газрын захиргаадад даалгасугай.
- Журмын хэрэгжилтэнд бодлого, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газар /Ш.Мягмар/, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эруул мэндийн газар /Т.Энхзаяа/-т тус тус үүрэг болгосугай.
- Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Журам батлах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2010 оны А-79/99 дүгээр хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.





Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 сарын
21-ны өдрийн дугаар хамтарсан
тушаалын нэгдүгээр хавсралт

РАШААНЫГ ЗОХИСТОЙ АШИГЛАХ, ХАМГААЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь рашааныг зохистой ашиглах, хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Журмын хэрэгжилтэд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Тусгай хамгаалалттай газар нутгийн болон сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч хяналт тавина.

Хоёр. Рашааны нөөцийн хайгуул, судалгаа

2.1.Рашаан, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг тогтоох хайгуул, судалгааны ажлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгодог "Усны мэргэжлийн байгууллага"-ын эрхтэй хуулийн этгээд гүйцэтгэнэ.

2.2.Рашаан, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг тогтоох хайгуул, судалгааны ажлыг улс, орон нутгийн төсөв болон хүн, хуулийн этгээдийн хөрөнгөөр санхүүжүүлж болно.

2.3.Рашааны хайгуул, судалгааны ажлын үр дүнгийн тайланд дараах үзүүлэлтүүд тусгагдсан байна. Үүнд:

2.3.1.Рашааны газар зүй, геоморфологи, геологийн тогтоц, тектоник бүтэц, гидрогоеологийн нөхцөл;

2.3.2.Рашааны физик–химийн шинж чанар, найрлагыг тодорхойлсон ажлын үр дүн, дүгнэлт;

2.3.3.Рашаан орчмын ургамал, амьтан, бичил биетний бүрэлдэхүүн, нөхцөл байдлын өөрчлөлтийн дүгнэлт.

2.4.Рашааны нөөцийн хайгуул, судалгааны ажлын үр дүнгийн тайланг Усны нөөцийн зөвлөлөөр баталгаажуулж, улсын усны мэдээллийн санд бүртгэнэ.

2.5.Хайгуул, судалгаагаар ашиглах боломжит нөөц нь батлагдсан рашааны орд бүр паспорттой байна.

2.6.Рашааны ордын паспортыг тухайн сав газрын захиргаа, рашаан ашиглагчид олгож, мэдээллийн дэд санд оруулна.

2.7.Рашааны ордын паспортыг рашаан ашиглагч хөтөлж, сав газрын захиргаа хяналт тавина.

Гурав. Рашааныг хамгаалах, ашиглах болон рашааны хамгаалалтын бүс

3.1.Рашааныг хамгаалах харилцааг Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.10-22.18 дахь хэсэгт зааснаар зохицуулна.

3.2.Тухайн сав газрын захиргаа нь энэхүү журмын 3.1-д заасан рашааны бүсийг тухайн сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулна.

3.3.Рашааны эрүүл ахуйн бүсийг хашаажуулах, хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх арга хэмжээг рашаан ашиглагч хариуцаж, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

3.4.Рашаан ашиглагч нь Усны тухай хуулийн 28.2, 28.3-т заасан баримт бичгийг бүрдүүлж, тухайн сав газрын захиргаагаар рашаан ашиглуулах дүгнэлт гаргуулна.

3.5.Сав газрын захиргааны рашаан ашиглуулах дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн байгаль орчны алба зөвшөөрөл олгож, гэрээ байгуулна.

3.6.Рашаан ашиглагч нь рашааны эмчлэх чадварыг эмнэл зүйн туршилтын үр дүнд суурисан холбогдох эрдэм шинжилгээний байгууллагын дүгнэлтийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлөөр гаргуулсан байна.

3.7.Рашаан ашиглагч нь рашааны чанар, найрлагыг хагас жилд нэг удаа, бохирдлын үзүүлэлтийг улиралд нэг удаа өөрийн хөрөнгөөр хийлгэж, шинжилгээний дүнг тухай бүр сав газрын захиргаанд хүргүүлнэ.

3.8.Рашаан ашиглагч нь рашааны эх орчмыг тохижуулж, түүний голдирлыг үл хөндөн шугам сүлжээгээр боломжит нөөцийн хэмжээнд авч ашиглана.

3.9.Рашаан ашиглагч нь эрүүл ахуйн болон хамгаалалтын бүс, түүний орчмын хөрс, геоморфологийн нөхцөлийг доройтуулахгүй байх, нөхөн сэргээх үргийг хүлээнэ.

3.10.Рашааны нөөцийн хайгуул, судалгааг өөрийн хөрөнгөөр хийж, тохижуулан тоноглосон хүн, хуулийн этгээд нь Усны тухай хуулийн 28.14, 28.15-д заасны дагуу ашиглана. Рашааны нөөц илүү гарах нөхцөлд бусад хүн, хуулийн этгээдэд ашиглуулж, зарцуулсан зардлыг нөхөн төлүүлж болно.

3.11.Рашаан ашиглагч нь хаягдал ус цэвэрлэх, дахин ашиглах барилга байгууламжтай байх бөгөөд ахуйн хэрэглээ болон үйлдвэрлэл үйлчилгээнээс гарч буй хаягдал усыг хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх бол Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015, ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх бол Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага. MNS 6561:2015 стандартад нийцүүлэн цэвэрлэх үүрэг хүлээнэ.

3.12.Рашааны нөөц, түүнээс ашиглах боломжит нөөцийг тогтоогоогүй бол үйлдвэрлэл үйлчилгээ, сувиллын үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.

Дөрөв. Рашаан ашигласны төлбөр

4.1.Рашаан ашиглагч нь Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.2 дахь хэсэгт заасан үүрэг хүлээх ба рашаан ашигласны төлбөрийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт зааснаар тооцож төлнө.

4.2.Рашаан ашиглагч нь үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар рашааныг ашиглах тохиолдолд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-15.5-т заасны дагуу рашаан ашигласны төлбөр төлнө.

4.3.Ус, рашааны нөөцийг ашиглан хаягдал ус гаргаж, усны найрлага, чанарт нөлөөлж байгаа ус бохирдуулагч хүн, хуулийн этгээд ус бохирдуулсны төлбөр төлнө.

Тав. Рашааны орд, эх булгийн чанар, аюулгүй байдлын хяналт, шинжилгээ

5.1.Рашааны нөөцийн хайгуул, судалгааны ажлын явцад усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сав газрын захиргаа хяналт тавина.

5.2. Рашааны чанар, эрүүл ахуй, бохирдлын үзүүлэлтүүдэд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавина.

5.3.Рашаан ашиглагч нь рашааны нөөц хомсдож, чанар нь алдагдахаас сэргийлж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

5.3.1.рашааны худагт улирал тутам нэг удаа хяналт-шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ;

5.3.2.рашааны эх булаг, ундарга бүрээс ашиглалтын эхний жилд сард нэг удаа дээж авч, рашааны чанарын шинжилгээ хийлгэж, дараагийн жилээс улиралд нэг удаа дээж авч, хяналтын шинжилгээ хийлгэнэ;

5.3.3.рашааны чанарт сөргөөр нөлөөлөхгүй, стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан тоног төхөөрөмжийг үйлдвэрлэл-үйлчилгээ, эмчилгээний үйл ажиллагаанд ашиглана;

5.3.4.рашаан ашигладаг байнгын ажиллагаатай амралт, сувилал нь эрүүл ахуйн шинжилгээг улиралд нэг удаа, улирлын ажиллагаатай амралт, сувилал нь сард нэг удаа эрүүл ахуйн болон бохирдлын шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, холбогдох зардлыг хариуцна.

5.3.5.Рашааны чанарын эрүүл ахуйн бохирдлын үзүүлэлтүүд (нян, нитрит, нитрат) Эмчилгээ ундааны зориулалтаар савлаж хэрэглэх рашаан, техникийн шаардлага MNS 3651:2004 стандартаас давсан тохиолдолд бохирдлыг бууруулах арга хэмээ авч, үр дүнг шинжилгээгээр баталгаажуулж, шалтгааныг тодорхойлох зорилгоор давтан шинжилгээ хийнэ.

5.3.6.Давтан шинжилгээгээр илэрсэн үзүүлэлтүүдийг рашааны ордын паспортод тэмдэглэнэ.

5.3.7.Рашаан ашиглагч нь рашааны чанар, найрлагатай холбоотой батлагдсан стандартыг мөрдөж ажиллана.

5.3.8.Рашааны нөөцийг ашиглан үйл ажиллагаа явуулж (сувилах, савлах, түгээх, тээвэрлэх гэх мэт) буй хүн, хуулийн этгээдийн албан хаагчид эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан байна.

5.3.9.Рашаан ашиглагч нь рашаан авах худаг, цооног, шугам хоолой бүрийг тооцууржуулна.

Зургаа. Рашааны ашиглалт, хамгаалалтын мэдээ, тайлан гаргах

6.1.Рашаан ашиглагч нь рашаан ашиглахтай холбоотой мэдээ, тайланг аймаг, нийслэлийн Байгаль орчны албанд хүргүүлж, бүртгүүлнэ.

6.2.Байгаль орчны алба нь рашаан ашиглах гэрээг дүгнэж, жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний дотор тухайн сав газрын захиргаанд хүргүүлнэ.

6.3.Сав газрын захиргаа нь рашааны ашиглалт, хамгаалалт, төлөв байдлын мэдээ тайланг нэгтгэн боловсруулж, жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудад хүргүүлнэ.

Долоо. Рашааны мэдээллийн санд бүрдүүлэх материал

7.1.Сав газрын захиргаа нь рашааны мэдээллийн санд дараах мэдээллийг бүртгэнэ:

7.1.1.Рашааны эрэл хайгуулын тайлан, рашааны нөөцийн хэмжээ (m^3 /хоног), бальнеологийн судалгааны мэдээ;

7.1.2.Рашааны мэдээлэл нь төрөл, байршил, талбайн хэмжээ, судлагдсан байдал, батлагдсан нөөц, ашиглах боломжит нөөцийн хэмжээ, химийн чанар, найрлага, ашиглалт, хамгаалалт болон бусад;

7.1.3.Рашааны эрүүл ахуйн болон хамгаалалтын бус, хориглолтын бус, хязгаарлалтын /тэжээгдлийн муж/ бусийн хилийн заагийг тогтоосон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол;

7.1.4.Рашааны ашиглалтын хэмжээ, хяналт шалгалтын дун, байгаль орчинд нелөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт болон бусад мэдээллийд.

Найм. Бусад

8.1. Энэхүү журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээд, албан тушаалтанд Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ооОоо



Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Эрүүл мэндийн сайдын 2020 оны 09...
29....-ны өдрийн 20/09/2020 дугаар
хамтарсан тушаалтын хоёрдугаар хавсралт

РАШААНЫ ОРДЫН ПАСПОРТ

20 он



УЛСЫН УСНЫ МЭДЭЭЛЛИЙН САН

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Эрүүл мэндийн сайдын 2020 оны
Дугаар хамтарсан тушавалын
хөөрдүгээр хавсралт

ПАСПОРТ ХӨТЛӨХ ЗДАВАР

- 1.Рашааны ордын паспортыг хөтөхөөс ёмне паспортын хэсэг бүртэй нарийн танилцаж, уншиж судалсан байна.
- 2.Рашааныг ашиглагч хүн, хуулийн этгээд нь паспортыг завал бурэн хөтөлсөн байна.
- 3.Рашааны орд, рашааны паспортыг Сав газрын захиргаа олгож, улсын усны мэдээллийн санд бүртгэсэн код, дугаартай байна.
- 4.Паспортын тэмдэглэээ дутуу тохиолдолд баталгаажуулалт хийхийг хорилно.

ПАСПОРТ ЭЗЭМШИГЧИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 1.Паспортад хавсралт, шинжилгээний дун, рашааныг ашиглах зөвшөөрөл, паспортын хамт хадгалсан байх;
- 2.Рашааныг усны тоо бүртгэлд хамруулсан байх;
- 3.Хяналтын байгууллагаас тавьсан шаардлагыг тогтоосон хугацаанд нь биелгүүн аливаа өөрчлөлт орсон тохиолдолд журамд заасны дагуу паспортод тэмдэглүүлсэн байх;
- 4.Рашаанд хийсэн шинжилгээ, орчны тохижуулалт, хаддвартайжуулэлтийн жэлтын талзарх арга хэмжээг тухай бүрд тайллан гарган паспортод хавсаргасан байх.

РАШААНЫ ОРДЫН ПАСПОРТ



20..... он

ХАЯГИЙН ХЭСЭГ:

Бүсчлэлийн код:

Аймаг, Нийслэл, сум, дүүрэг, хороо

6. Паспортод хавсаргасан материалууд

1. Рашиааны эх булгийн нэр

2. Рашиааны орд оршиж байгаа газрын нэр, хаяг

7. Паспорт хүлээн авагчийн албан тушаал, гарын усэг, нэр

Уртраг

Өргөрөг:

Үнэмлэхийн ондөр,

..... М

(Газар зүйн байршилыг градус, мин, сек, WGS 84-ээр илрэхийж бичнэ)

8. Паспортыг баталгаажуулсан:

3. Рашиааны орд, эх булгийг ашиглагчийн нэр /иргэн, аж ахуйн нэр/,
байгууллага/

Сав гарын захиргаа

Тамга

4. Рашиааны орд, эх булгийг хэзээж ямар байгууллага анх ашигласан

5. Рашиааны орд, эх булагт ямар байгууллага, хумуусээс засвар тохижуулалт хэзээ хийсан, ямар тоног төхөөрөмж тавьсан

20.... он сар өдөр

**Рашааны ордын паспорт олгоход эрүүл ахуй, техникийн
байдал, рашааны чанар, ашиглалт**

1. Рашааны боломжит нөөц, ус зүй, эрүүл ахуй, техникийн
узүүлэлт
а/ Рашааны ундарга хаанаас тэжээлдэг /хөрсний уст давхрагад
хамаардах эсэх зэрэг/

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

б/ Гүний өрөмдмэл худаттай рашаан:

батлагдсан боломжит нөөц М³/ХОНОГ
ундарга М³/С, (Л/С) га
тархалтын талбай га
өрөмдсөн гүн М
худгийн гүн М
рашааны тогтолчи тувшин М
рашааны хөдөлгөөнт тувшин М
цоногийн диаметр М
ус өргүүр суулгасан гүн М
ус өргөх хоолойн голч, төрөл М

в/ Рашааны эх булаг гадаргын урсацтай бол:

илэрчийн тоо л/с
ашиглаж боломжит нөөц га
тархалтын талбай га
урсгалын хурд М/С
гүн М
өргөн М
ус дамжуулах хоолойн голч, төрөл М

ус өргүүрийн, марк, хүчин чадал л/с

2. Рашааны орд, эх булагийн хамгаалалт тохижилтын байдал:

- а/ Рашааны орд, эх булаг, ундаргад эрүүл ахуйн, хамгаалалтын бус
тогтоосон байдал

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

б/ Рашааны орд, эх булагийг бохирдолтоос хамгаалсан байдал

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

в/ Рашааны ашиглалт:

а/ рашаан ашиглаж байгаа арга /шахуурга, дамжуулах хоолой, цорго
гэх мэт/
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

б/ Тоогтуурын марк, төрөл, хэмжээ, отноо

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

в/ рашаанаар үйлчлүүлэгчдийн хамрах хүрээ, хүн / хоног, /жилзэр/

5. Рашаан усны физик шинж чанар

Үзүүлэлтүүд	Рашааны илэрц
Өнгө	
Үнэр	
АМТ	
Тунгалаг чанар	
Тунадас	
Булингар	
Температур °С	
Урвалын орчин, pH	

4.Рашааны орд, эх булгийг сонгон авахад эргүүл ахуй болон мэргэжлийн байгууллагаас өгсөн дүнгэлтийн товч агуулга, огноо

Паспорт олгохос өмнөх рашааны найрлагад хийсэн шинжилгээний дүн

Үзүүлэлтүүд	Эмчилгээний шаврын илэрц
Өнгө	
Үнэр	
0.25 ММ-ЭЭС ТОМ хэсгийн хэмжээ, %	
Чийгшил/ %	
Хувийн жин, г/см ³	
Урвалын орчин, pH	
Дулаан барих чадвар	

6. Химийн найрлага

Голлох катион		Бальеологийн үзүүлэлт	Бусад бүрэлдэхүүн	Лабораторийн хэрэгжүүлэлт			
				CO ₂ /H ₂ S / H ₂ SiO ₃ / H ₃ BO ₃ мийн тохиолдсандаа хинчих сарын заман			
				Yperaturin opahin, pH			
				Xarhart хинчих сарын заман			
				Линхкүнүүсээ хинчих багийн нутгаар, язгуурноо			
				Тодорхойжсандаа хинчих сарын заман			
				Magniin (Mg^{2+})			
				Kalziniin (K^+)			
				Natriuin (Na^+)			
				Lithiin (Li^+)			
				Kalziniin (Ca^{2+})			
				Magniin (Mg^{2+})			
				Kalziniin (Na^+)			
				Hartn (Li^+)			
				Kalziniin (CO_3^{2-})			
				Xhoniin (Cl^-)			
				Temep (Fe^2+)			
				Opto luxnypbiin			
				Xyhnin (H_4SiO_4)			
				Terperi (C_{60}^+)			
				Boginiin (H_3BO_3)			
				Optop			
				Ammoniin (NH_4^+)			
				Hintpar (NO_3^-)			
				Kuntt, r/n			
				Лабораторийн хэрэгжүүлэлт			

6.2. Эмчилгээний шаврын микро элементүүд

Шинжилгээ хийсэн байгууллага, лабораторийн нэр, огноо	Хяналт хийсэн хугацаа	Микро-элемент, рpt /10 ⁶ /	Орийн эмчилгээний шаврын микро элементүүд
		Bi /висмут/	
		Co /cobalt/	
		Cr /хром/	
		Cs /цезий/	
		Cl /зэс/	
		Ga /галлий/	
		Ge /германий/	
		Hf /гафний/	
		Mo /молибден/	
		Nb /ниобий/	
		Ni /никелий/	
		Rh /рений/	
		Zn /цинк/	
		Sr /стронций/	
		Ta /тантал/	
		Th /торий/	
		V /ванадий/	
		W /вольфром/	
		Y /игтирий/	
		La /актиний/	
		Zr /цирконий/	
		Sc /скандий/	
		Sn /санарий/	
		Pr /прасодий/	
		Ce /церий/	
		Nd /неодим/	
		U /уран/	
		Ba /варий/	
		As /хүчинэл/	
		Pb /хар туталга/	
		Sb /сурыма/	

Паспорт олгосноос хойш рашааны эх булагт хийсэн хяналт, авсан арга хэмжээ

1. Рашааны орд, эх булгийн эрүүл ахуй, ашиглалт, хамгаалтын тухай хяналтын тэмдэглэл

2.Рашааны орд, эх булагт хийсэн химийн шинжилгээний дун үзүүлэлт буреэр

3. Ашиглалтын хугаанд ращааны чанарт хийсэн эрүүл ахуй, бактериологийн шинжилгээ

4. Рашиааны эх булагийн эрүүл ахуйн болон хамгаалалтын бусэд хийсэн тохижилт хамгаалалтын ажил

Дэс дугаар	Огноо	Хийсэн засвар тохижуулалтын ажил		Хяналтын байгууллагын шаардлагатай хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ	

5. Рашиааны орд, эх булаг, орчны тохижилт, цэвэрлэгзэ, халдваргүйжүүлэгтийн Байдалд хийсэн хяналт

Дэс дугаар	Огноо	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Гүйцэтгэсэн байгууллага, хүний нэр	Ажлын үр дүн	Хяналт тавьсан байгууллага, ажилтны нэр

Бүрэлдэхүүнээр ... 204.....

